



## FACT SHEET - TUBERCULOSIS



Landessanitätsdirektion für Tirol

Mongolian

### Мэндчилгээ

Сайн байна уу? Би та бүхэнд сүрьеэ өвчний талаархи мэдээллийг хүргэх гэж байна. Үүний олон улсын нэршил нь Tuberculosis бөгөөд TB гэж товчилно. Энэхүү өвчнөөр жил бүр дэлхий олон сая хүн өвчилж, зовж шаналсаар байна.

Сүрьеэгийн тохиолдол нь дэлхийн улс орон бүрд харилцан адилгүй байдгаас энэхүү өвчний талаархи ойлголт, болон сүрьеэгийн эсрэг хэрэгжүүлдэг авах арга хэмжээ нь хүртэл янз бүр байдаг. Цаашилбал, сүрьеэгийн эсрэг эмчилгээнд зарцуулах санхүүжилт болон боловсон хүчнүүдийн бэлтгэгдсэн байдал нь ялгаатай. Тиймээс магадгүй энд өгүүлэгдэх зарим мэдээлэл ач холбогдолгүй эсвэл буруу ташаа мэт санагдаж болох юм. Гэвч сүрьеэтэй бүх өвчтөнүүдэд байдаг нийтлэг шинж бол уг өвчний улмаас бүх өвчлөгсөдийн амьдралд үргэлж өөрчлөлт гарч байдаг явдал юм. Дараахи мэдээлэл нь та бүхэнд сүрьеэ өвчний шалтгаан, үүнийг хэрхэн оношилж эмчилдэг талаархи ерөнхий ойлголтыг өгөх болно. Хэрэв та энэ өвчнөөр өвдсөн бол бид танд чин сэтгэлээсээ хурдан эдгэрэхийг хүсэн ерөөе!

### Шинж тэмдэгүүд

Бие махбодьд явагдаж байгаа үрэвслийн урвалын нөлөөгөөр сүрьеэ өвчний шинж тэмдгүүд илэрч эхлэх ба уг өвчний явц нь маш удаан. Тиймээс өвчтөнүүд эмч дээр очтлоо хэдэн сарын турш зовиурласан байх нь элбэг. Сүрьеэгийн үед илрэх нийтлэг шинж тэмдгүүдэд удаан хугацаагаар ханиалгах, халуурах, шөнө хөлрөх, турах зэрэг шинжүүд орно. Зарим өвчтөнүүд хэт хөлөрснийхөө улмаас шөнөдөө хэд хэдэн удаа ор дэвсгэрийнхээ даавууг солих нь бий. Ихэнхи өвчтөнүүд жингийн эрчимтэй алдагдлаасаа өвчнөө анх анзаарах нь тохиолдоно. Та энэхүү мэдээллийг авснаараа гэр бүл болон найз нөхөддөө сүрьеэгийн үед гардаг нийтлэг зовиуруудыг мэдээллэж, улмаар тэд ч мөн өөрт өвчин байгаа эсэхээ анзаарч мэдэх боломж бүрдэнэ.

## **Эмчлэгдэх боломж**

Тухайн халдварлагдсан сүрьеэгийн савханцарууд антибиотикт мэдрэг бол эмчилгээний үр дүн гайхалтай байх болно. Хэдий тийм боловч эмээ бүрэн уух дүрмийг баримтлах ёстой. Хэрвээ биеийн байдал сайжрангуут эмээ уухаа удалгүй зогсоочихвол эсвэл тогтмол уухгүй бол өвчин дахиж, эмчлэхэд төвөгтэй болж эхэлнэ. Тэр ч бүү хэл, лабораторийн шинжилгээгээр нян биеэс олдохоо больсон ч эмчилгээний албан ёсны хугацаагаа дуустал эмээ уусаар байх нь туйлын ухаалаг явдал юм. Учир нь цөөн хэдэн нян биед үлдсэн байж болзошгүй бөгөөд эмчийн заавраар эмчилгээг бүрэн дуусгаснаар эдгээр нуугдсан нянгуудыг үл мөргүй усатгах болно. Тамхи татахаа болих нь эмчлэгдэх боломжийг дээшлүүлдгийг санах хэрэгтэй. Зарим төрлийн сүрьеэ, ялангуяа төв мэдрэлийн тогтолцоонд буюу тархи, тархины хальс сүрьеэгийн халдварт өртсөн бол амь насанд ноцтой аюултай тул яаралтай оношилгоо, эмчилгээ шаардагдана. Янз бүрийн архаг өвчнүүд, дархлааны хямрал, ялангуяа хүний дархлал хомсдолын вирүсийн халдвар нь сүрьеэ өвчний идэвхижил, хүндрэл зэрэгт нөлөөлдөг. Дээр дурьдсанчлан эмэнд дасалтай сүрьеэг эмчилэхэд төвөгтэй, эмчлэгдэх боломж харьцангуй. Нөгөө талаас зарим улс оронд үүнийг эмчлэгдэхэд хэрэглэгддэг эм байхгүй, эсвэл боловсон хүчин нь хангалттай бэлтгэгдээгүй байдгаас эмэнд дасалтай сүрьеэг эмчлэх чадавхи нь улс оронд бүрд өөр өөр байдаг.

## **Тархалтын урьдчлан сэргийлэлт**

Хэрэв ханиалгаар сүрьеэгийн нянгууд ялгарсаар байвал тухайн өвчтөн бусдад халдвар тараах аюултай гэсэн үг. Иймээс өвчтөн ханиалгах, найтаалгах үедээ хамар амаа алчуураар таглах ёстой. Харин өөрийн алчуураа бусдадтай солилцох эсвэл хувааж хэрэглэж болохгүй. Хэрэглэсэн алчуураа халаасандаа хадгалж, хэрэв нэг удаагийн цаасан алчуур хэрэглэсэн бол шууд хаяж байх хэрэгтэй. Хэрвээ танд алчуур байхгүй бол ханиалгах болон найтах үедээ тохойны нугалмаараа, эсвэл ханцуйгаараа хаах нь зөв. Харин гараараа таглах, нус цэрээ газар луу нулимж болохгүй. Өрөө тасалгаанд байх хугацаандаа халдвартай өвчтөнүүд бусадтай харьцах үедээ хамар амаа бүрэн хучсан хамгаалалтын нүүрний маскыг зүүх шаардлагатай. Мөн өрөө тасалгаагаа тогтмол агааржуулж, нарны гэрлийг оруулж байх хэрэгтэй. Учир нь ханиалга болон амьсгалаар ялгарсан нянгууд тасалгаанд хэдэн цагаар оршдог. Түүнчлэн тухайн өрөөнд орж ирэх хүн бүр хамгаалалтын маскыг мөн өмсөх ёстой. Хэрэглэгдэх маскууд нь FFP2 эсвэл N95-ийн стандартад нийцсэн тусгай амны хаалтууд бөгөөд өвчтөнг эргэн ирж буй бүх найз нөхөд болон ар гэрийхнийг хамгаалж чадна.

## **Тусгаарлалт**

Халдваргүй болох хүртлээ өвчтөн бусдад халдвар тараахгүйн үүднээс хэд хэдэн журмыг сайтар баримтлах шаардлагатай. Үүнд, тодорхой хугацаанд эмнэлгийнхээ өрөөнөөс гарч болохгүй ба уг дүрэм нь нилээд хэдэн орнуудад мөрдөгддөг. Ялангуяа ханиалгаар нян ялгарсаар байгаа бол эмнэлгийнхээ өрөөнөөс гарах нь хориотой юм. Иймээс танд шаардлагатай бүх зүйлс эмчлүүлж буй өрөөнд хангагдана. Зарим сүрьеэгийн тохиолдол өндөртэй газруудад өвчтөнөө эмнэлгээс гарч алхах, цаашилбал гэртээ харихыг ч зөвшөөрдөг. Гэвч ямар ч тохиолдолд зайлшгүй мөрдөх шаардлагатай дүрэм бол: хэрвээ та халдвартай л бол та болон таныг эргэж ирж буй бүх хүн тусгай хамгаалалтын маск зүүх ёстой. Түүнчлэн та богино хугацаагаар (жишээ нь: шинжилгээ хийлгүүлэхээр) өрөөнөөсөө гарах тохиолдолд мөн адил амны хаалт зүүх шаардлагатай. Хамгаалалтын маскыг зүүхдээ хамар, амаа бүрэн хучина. Хэрвээ хэрэглэж байгаа маскын хэмжээ тань нүүрэнд тохирж байгаа бол маскын хажуу хэсгээр агаар нэвтрэх эсвэл гарах ёсгүй. Эмч болон сувилагч нар танд хэрхэн зөв зүүх талаар тайлбарлаж өгөх болно.

## **Эмчилгээний талаархи ерөнхий мэдээлэл**

Сүрьеэ өвчнийг тодорхой антибиотикийн хослолоор эмчилдэг. Ихэнхи тохиолдолд эмчилгээний үр дүнд сүрьеэ ул мөргүй амжилттай эдгэрдэг. Харамсалтай нь сүрьеэгийн эмчилгээ олон сараар удаан үргэлжлэх тул маш их тэвчээр шаардлагатай. Өөрөөр хэлбэл та олон сарын турш олон эм уух бөгөөд эмнүүдээ тогтмол уух нь онцгой чухал. Эмчилгээ 2 шаттайгаар хийгдэнэ. Хоёр ба түүнээс дээш сар үргэлжилдэг эхний эрчимт үед 4 төрлийн антибиотикийн хослол хэрэглэгдэх ба дараагийн шатнаас эхлэн эмийн тоо цөөрдөг. Сүрьеэгийн удаан хугацаат эмчилгээг хялбарчлах үүднээс нилээд олон оронд тохирсон тун бүхий бэлэн хослолыг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл 2-4 эмийг нэг шавхмалд багтаасан гэсэн үг юм. Гэвч зарим орон одоог хүртэл ийм төрлийн эмийг хэрэглэж эхлээгүй байгаа тул эдгээр орнуудын өвчтөнүүд өдөрт нилээд хэдэн шахмалыг уусаар байна. Хэдийгээр өдөрт олон шахмал уух нь төвөгтэй ч гэлээ, эмээ тогтмол уух нь асар чухал. Хэрвээ та эмээ тогтмол уухгүй бол эмчилгээ амжилтгүй болж, таны бие дэхь усатгагдаагүй нянгууд дахин үржиж, тэдгээр шинэ удмын нянгууд нь эмэнд тэсвэртэй болсноор илүү удаан хугацааны эмчилгээ шаардлагатай болно. Бүр цаашилбал эмчлэгдэх боломжгүй болж амь насаа алдах хүртэл эрсдэлтэй.

### **Хурдан эдгэрэхэд өвчтөний хувь нэмэр**

Сүрьеэтэй ямар ч өвчтөн амархан аргаар өөрийгөө хурдан эдгэрэхэд тусалж чадна. Жишээ нь тамхи татахгүй байх, учир нь тамхичдын эдгэрэлт нь тамхи татдаггүй хүмүүсийнхээс илүү удаан байдаг нь судалгаагаар батлагджээ. Мөн өрөө тасалгаага тогтмол агааржуулах хэрэгтэй. Хамгийн чухал нь, эмнүүдээ цаг тухайд нь тогтмол уух явдал бөгөөд ингэснээр сүрьеэ өвчин хурдан амжилттай эдгэрэх болно. Хэрвээ архи, мансууруулах бодис хэрэглэдэг бол тэдгээрийг эмчилгээний хугацаанд цээрлэх нь зөв. Учир нь ямар ч төрлийн согтууруулах болон мансууруулах төрлийн бодис дархлаа тогтолцооны үйл ажиллагааг сулруулдаг. Хэрвээ өөрийн хорт зуршлуудаа таслан зогсоож чадахгүй байгаа бол эмчлэгч эмчтэйгээ зөвлөлдөх нь зүйтэй. Ингэснээр эмчилгээ амжилттай явагдаж, сүрьеэ өвчин бүрэн эдгэрэх баталгаа бий болно.

Name der Bezirksverwaltungsbehörde:  
(name of district administrative authority)

Name des Patienten:  
(name of patient)

Geburtsdatum:  
(date of birth)

---

Datum, Unterschrift  
(date, signature)

---

Datum, Unterschrift  
(date, signature)



App with text-to-speech function for Apple iOS and Android for  
[www.explaintb.org](http://www.explaintb.org)